



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/146

Мандалговь

Г Ажлын хэсэг байгуулах тухай 7

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, 29.1.5 дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалт, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалт, Харилцаа, холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Барилга, хот байгуулалтын Сайд болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 4 дүгээр хавсралтын 6-д заасан "Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэх, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Эрдэнэ-Очир /Аймгийн Засаг даргын тамгын газрын
ХОХБТХ-ийн дарга/
Ч.Баярбаатар /"Дундговь-Ус" ОНӨҮГ-ийн ерөнхий
инженер/
Н.Гантулга /Байгаль орчин аялал жуулчлалын газрын
дарга/
Б. Энхтуяа /Аймгийн Статистикийн хэлтсийн дарга/
Э.Дашням / "Ган-Илч" ХХК-ны ерөнхий инженер/
Б.Батнаран "Тэвшийн говь" ХХК-ны менежер/
С.Энхбат /БЗӨБЦТС ТӨХК-ний Дундговь ЦТССалбарын
ерөнхий инженер/
Л.Баасансүрэн /"Мэдээлэл холбооны сүлжээ" ХК-ний
Дундговь салбарын ерөнхий инженер/
Д. Мөнхцоож /Сайнцагаан сумын Хот тохижуулах газрын
дарга/
Э.Энхмэнд /Аймгийн ГХБХБГ-ын Барилгын асуудал
хариуцсан мэргэжилтэн/

46819033

Нарийн бичгийн дарга: Д.Нэргүй /Аймгийн Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн
дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор/

2. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх, үйл
ажиллагаа, зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулж батлуулан, хэрэгжилтийг
хугацаанд нь хангуулж, тайлан, төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, геодези, зураг
зүйн газарт хүргүүлж ажиллахыг Ажлын хэсэг /Н.Эрдэнэ-Очирт/ даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ